

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 01 сарын 18 ны өдөр

Дугаар 5/А/10/06/06 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын 3 дугаар заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Айл өрхийн болон аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөхтэй холбоотой гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, санхүүжүүлэх арга хэмжээ авах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Ганбат

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Гишүүд:

М.Батхуяг

Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга

Ч.Чимидсүрэн

Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга

Э.Ганхүү

Барилга, хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

А.Энхбат

Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Х.Отгонзул

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

Б.Тэлмүүн

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга

М.Санжаадорж	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга
Б.Болор-Эрдэнэ	Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ тариф, зах зээлийн газрын дарга
Ж.Гэрэлчулуун	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Үнэ тарифын албаны дарга
Д.Үүрийнтуяа	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч захирал

Хоёр. Айл өрхийн болон аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрөөс хариуцан төлөхтэй холбоотой гүйцэтгэлийг санхүүгийн болон бусад шаардлагатай баримт бичгийн хүрээнд тухай бүр түргэн шуурхай хянан баталгаажуулж санхүүжилтийг холбогдох байгууллагуудад шилжүүлж байхыг ажлын хэсэгт даалгасугай.

